



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН НИЙЦЛИЙН АУДИТ

ХУУЛИЙН ТУХАЙ, ХУУЛЬД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ




Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд 4 бүлэг 22 зүйл заалттай батлагдсан.

2022 онд 1 удаа

2023 онд 2 удаа

2024 онд 3 удаа

ӨМНӨХ ОНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ



- 2022 онд 2,547.8 сая ₮
- 2023 онд 401.3 сая ₮
- 2024 онд 298.6 сая ₮

Нийт 3,247.8 сая төгрөгийн 66 зөрчлийг илрүүлэн, арилгах арга хэмжээг авсан байна.

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

- Орлогчийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгохгүй байх.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

- Төрийн захиргааны ангиллын албан тушаалд Төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт ажилтан ажиллуулахгүй байх.

Баян-Өндөр Сумын Засаг даргын Тамгын газарт:

- Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаах.
- Төрийн захиргааны ангиллын албан тушаалд Төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт ажилтан ажиллуулахгүй байх.
- Багийн хэсгийн ахлагч нэртэй гэрээт 130 ажилчдын холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

- Төсвийн шууд захирагч нараас хуулийн дагуу худалдан авахаар төлөвлөсөн 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг гаргуулан авч цахим дэлгүүрт байршуулах ажлыг зохион байгуулах.

Аудитын дэлгэрэнгүй тайланг open.audit.mn

Орхон аймаг
2025 он